



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 22

Алтай хот

Татварын хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг хавсралтаар тогтоосугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга дарга (В.Рэнцэндорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА ~~Л.Батжаргал~~ Л.БАТЖАРГАЛ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2019 оны 2 дугаар сарын 05-ны
өдрийн 2 дугаар тогтоолын хавсралт



БИЧИЛ ХУДАЛДАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ХУВЬ ХҮНИЙ САРД
ТӨЛӨХ ТАТВАРЫН ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Ажил үйлчилгээний төрөл	Шинээр тогтоох хэмжээ /хөдөлмөрийн хөлсний доод хэмжээни хувиар/	2020.01.01-ээс авах татвар /төгрөгөөр/
1	Ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай, худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн	1.4 хувь	6000
2	Аймаг, суманд такси үйлчилгээний эрхлэгч хувь хүн	5 хувь	21000
3	Зорчигч тээврийн үйлчилгээний эрхлэгч хувь хүн	11.9 хувь	50000
4	Ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэгч хувь хүн	5 хувь	21000